473.	8516	Ус хурдан буцалгагч, эсвэл халууныг хадгалдаг ус буцалгагч, дүрдэг халаагч; орчны агаарыг халаах цахилгаан аппарат болон газрын хөрс халаах аппарат; үсчний цахилгаан халаагуурт аппарат (жишээ нь: үс хатаагч, үс ороогч, үс буржийлгах хавчаарын халаагч) болон гар хатаагч; цахилгаан индүү; гэр ахуйн зориулалтын цахилгаан халаагуурт бусад хэрэгсэл
474.	85164000	Цахилгаан индүү
475.	85166000	Цахилгаан зуух
476.	8528	Телевизийн нэвтрүүлэг хүлээн авах аппаратгүй монитор болон проектор; телевизийн нэвтрүүлэг хүлээн авах аппарат (корпуст нь радиогийн нэвтрүүлэг хүлээн авах, дуу, видео бичлэг хийх, сэргээх аппарат угсрагдсан, эсвэл угсрагдаагүй)
477.	8528.72	Ахуйн зориулалттай телевизор
478.	8529	Радио, телефон, телеграф, телевизор, нэвтрүүлгийн аппаратуудын эд анги
479.	8531	Бусад дуут болон гэрлэн дохиот цахилгаан төхөөрөмж
480.	8532	Тогтмол, хувьсах, тохируулгат багтаамжийн цахилгаан конденсатор
481.	8533	Цахилгааны эсэргүүцэл хэмжих хэрэгсэл
482.	8534	Хэвлэмэл хэлхээнүүд
483.	8544	Тусгаарлагчтай утас (пааландсан, эсвэл аноджуулсан нь орно), кабель (коаксиаль кабель орно) болон холбогчтой хэсгээр тоноглогдсон буюу тоноглогдоогүй, тусгаарлагчтай бусад цахилгаан дамжуулагч; цахилгаан дамжуулагчтай хамт угсрагдсан, эсвэл угсрагдаагүй буюу холбогч хэсгээр тоноглогдсон, эсвэл тоноглогдоогүй, бүрээстэй мяндсаар хийсэн оптик мяндсан кабель
484.	8545	Төрөл бүрийн электрод
485.	8546	Төрөл бүрийн материалаар хийсэн цахилгаан тусгаарлагч
486.	8547	Цахилгаан машин, аппарат, төхөөрөмжийн зориулалттай, цутгах явцад угсрагдсан металлан аливаа жижиг хэсэг (жишээ нь: чийдэнгийн патрон)-ийг үл тооцсоноор бүхэлдээ тусгаарлагч материалаас бүрдсэн тусгаарлагч хэрэгсэл цахилгааны утасны зориулалттай, үндсэн металлаар хийсэн, тусгаарлагч материалаар доторлосон хоолой болон тэдгээрийн холбоос
487.	8548	Бусад цахилгаан эд анги хэрэглэл
488.	9101	Үнэт бугуйн болон халаасны цаг
489.	9102	Бугуйн болон халаасны бусад цаг
490.	9103	Ханын болон ширээний цаг
491.	9105	Бусад цаг
492.	9106	Бичлэгийн төхөөрөмжтэй бүртгэх зориулалттай цаг
493.	9107	Цагийн механизмт буюу цагийн хам хөдөлгүүрт хугацааны реле
494.	9108	Бугуй, халаасны цагны угсарсан буюу нийлүүлсэн байдалтай механизм



495.	9109	Бусад цаганд зориулсан угсармал буюу нийлмэл байдалтай механизм
496.	9111	Бугуйн ба халаасны цагны гэр (гадар), түүний эд анги
497.	9112	Бусад цагны гэр, тэдгээрийн эд анги
498.	9113	Бугуйн болон халаасны цагийн оосор, тууз, бугуйвч маягийн оосор
499.	9114	Бүх төрлийн цагны бусад хэсэг
500.	9201	Төгөлдөр хуур
501.	9202	Чавхдаст хөгжмийн бусад зэмсэг (гитар, хийл, босоо ятга)
502.	9205	Үлээвэр хөгжмийн зэмсэг (модон бишгүүр, бүрээ, хөөрөгт цуур)
503.	9206	Цохиур хөгжмийн зэмсэг
504.	9207	Цахилгаан хөгжмийн зэмсэг
505.	9208	Аялгуут хайрцаг
506.	9209	Хөгжмийн зэмсгүүдийн эд анги
507.	9401	Дэлгэгддэг буюу дэлгэгддэггүй мебель суудал, тэдгээрийн хэсэг
508.	9402	Эмнэлгийн зориулалттай мебель
509.	9403	Бусад мебель ба түүний эд анги
510.	94031000	Ажлын өрөөний төмөр мебель
511.	94032000	Бусад төмөр мебель
512.	94033000	Ажлын өрөөний модон мебель
513.	94034000	Гал тогооны өрөөний модон мебель
514.	94035000	Унтлагын өрөөний модон мебель
515.	94036000	Модон бусад мебель
516.	94037000	Хуванцар мебель
517.	94038100	Хулс буюу хулслаг дал модоор хийсэн мебель
518.	9404	Гудасны тавиур, гудас, хаваастай хөнжил, бүтээлэг, дэр, явган сандал
519.	9405	Гэрэлтүүлгийн хэрэгсэл, түүний эд анги
520.	9406	Гэрийн угсармал хийц
521.	9503	Тоглоомын загвар
522.	9504	Хөгжөөнт тоглоомын зүйлс
523.	9505	Баяр ёслол, багт наадам, илбэ болон тэдгээрт зориулсан зүйлс
524.	9506	Биеийн тамирын дасгал, гимнастик, хөнгөн атлетик болон бусад спортын (ширээний теннис орно), эсвэл талбайн тоглоомын зориулалттай, бусад газар заагдаагүй хэрэгсэл, төхөөрөмж, усанд сэлэлтийн болон завины уралдааны сан
525.	9506.11	Цана





526.	9507	Загасны уурга, дэгээ болон бусад хэрэглэл
527.	9508	Сонирхолтой бусад тоглоом
528.	9601	Сийлбэрт зориулсан амьтны гаралтай яс бусад материал (цутгамал зүйлс орно)
529.	9602	Сийлбэрт зориулсан ургамал эрдсийн гаралтай материал, тэдгээрээр хийсэн зүйлс
530.	9603	Шүүр, сойз, ариун цэвэр, гоо сайхан, бичгийн зориулалтын бийр, багс
531.	9604	Шигшүүр ба гар шигшүүр
532.	9605	Аяны цүнх, сав
533.	9606	Төрөл бүрийн товч, тэдгээрийн эд анги
534.	9607	Цахилгаан товч ба түүний эд анги
535.	9608	Тосон бал, эсгий болон сэвсгэр материалан хошуут фломастер болон маркер, бэхээр бичдэг үзэг, стилографын үзэг болон бусад үзэг, олшруулагч стилограф; эргэддэг, эсвэл автомат харандаа, үзэг тогтоогч, харандаа тогтоогч ба тэдгээртэй төстэй бусад тогтоогч
536.	9609	Төрөл бүрийн харандаа, цэрд
537.	9610	Зураг бичгийн зориулалттай самбар
538.	9611	Тамга, тэмдэг, дугаар тавигч, түүнтэй төстэй зүйл
539.	9612	Бичгийн болон түүнтэй төст машины лент, бэх
540.	9613	Тамхины асаагуур, чулуу, бялтаас бусад эд анги
541.	9614	Гаанс
542.	9615	Сам, үсний даруулга
543.	9616	Үнэртэн, ариун цэврийн ус шүршигч
544.	9617	Халуун сав
545.	9618	Хувцас, хувцасны загвар өмсгөх зориулалтын хиймэл хүн
546.	9619	Ариун цэврийн хэрэглэл, тампон, живх, нярайн живх болон янз бүрийн материалаар хийсэн, эдгээртэй төстэй зүйлс

## МОНГОЛ УЛС ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

### ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНД ЦАХИМ ХАРИЛЦААГ АШИГЛАХ ТУХАЙ НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН КОНВЕНЦ

Тус конвенцод оролцогч улс нь,

Тэгш эрх, харилцан ашигтай байх зарчимд тулгуурласан олон улсын худалдаа нь улс хоорондын найрсаг харилцааг дэмжих чухал хүчин зүйл гэдэгт илтгэж байгаагаа дахин нотолж,

Цахим харилцааг өргөнөөр ашиглах нь арилжааны үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлж, худалдааг өргөжүүлж, өнөөг хүртэл алслагдмал байгаа зах зээл болон Талуудыг хооронд нь ойртуулах таатай боломжийг нээж, ингэснээр олон улсын болон дотоодын худалдаа, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэхийг тэмдэглэж,

Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглахын эрх зүйн утга, агуулга тодорхой бус байгаагаас үүссэн асуудал нь олон улсын худалдаанд саад тотгор болж байна гэж үзэж,

Олон улсын гэрээнд цахим харилцааг ашиглахад тулгарч буй саад тотгор, түүнчлэн олон улсын худалдааны эрх зүйн баримт бичгийн хэрэглээнээс үүссэн саад тотгорыг арилгахад чиглэсэн эрх зүйн нэгдсэн зохицуулалтыг батлах нь олон улсын гэрээнд хууль ёсны байх зарчмыг хангах, арилжааны урьдчилан таамаглах нөхцөлийг сайжруулах, улсуудад орчин үеийн худалдааны замд нэвтрэх боломжийг олгоход тусална гэж итгэж,

Эрх зүйн нэгдсэн зохицуулалт нь технологийн төвийг сахих болон үйл ажиллагааны тэгш байдлын зарчмыг анхааралдаа авч, технологи болон зохих мэдээллийн хэрэгслийг сонгох Талуудын эрхийг хүндэтгэх, энэ хүрээнд Талуудын сонгосон арга хэрэгсэл хуулийн холбогдох зохицуулалтын зорилгод нийцсэн байх ёстой гэж ойлгож,

Эдийн засаг, нийгэм болон эрх зүйн өөр өөр тогтолцоотой улсуудын хувьд хүлээн зөвшөөрөхүйц байдлаар цахим харилцааг ашиглахад тулгарч буй эрх зүйн саад тотгорыг арилгах нийтлэг шийдэлд хүрэхийг эрмэлзэж,

Дараах зүйлийг тохиролцов:

## **I БҮЛЭГ. ҮЙЛЧЛЭХ ХҮРЭЭ**

### *1 дүгээр зүйл* **Хамрах хүрээ**

1.Үйл ажиллагаа явуулдаг газар нь өөр өөр улсад байгаа Талууд хооронд гэрээ байгуулах, эсхүл түүнийг биелүүлэхтэй холбогдуулан цахим харилцааг ашиглахад энэхүү конвенцыг хэрэглэнэ.

2.Талуудын үйл ажиллагаа явуулдаг газар өөр өөр улсад байгаа тухай гэрээ байгуулахын өмнө, эсхүл гэрээ байгуулах үед Талуудаас гаргасан мэдээлэл, Талууд хоорондын ажил хэргийн харилцаа, эсхүл гэрээнд дурдагдаагүй бол тус нөхцөлийг харгалзан үзэхгүй.

3.Энэхүү конвенцыг хэрэглэх тухай шийдвэр гаргахдаа Талуудын аль улсад харьяалалтай, аж ахуй эрхлэгч эсэх, эсхүл тухайн гэрээ арилжааны, эсхүл иргэний эрх зүйн шинжтэй эсэхийг харгалзан үзэхгүй.



*2 дугаар зүйл*  
**Үл хэрэглэх нөхцөл**

1.Энэхүү конвенц нь дараах цахим харилцаанд үйлчлэхгүй:

(a) Гэр бүлийн, гэр ахуйн, эсхүл хувийн зорилгоор байгуулсан гэрээ;

(b) i) Зохицуулалттай биржийн зах зээлд хийсэн гүйлгээ; (ii) гадаад валютын гүйлгээ; (iii) банк хоорондын төлбөр тооцооны систем, банк хоорондын төлбөр тооцооны гэрээ, эсхүл үнэт цаас болон бусад санхүүгийн хөрөнгө, хэрэгсэлтэй холбоотой банк хоорондын төлбөр тооцооны хэлбэр; (iv) зуучлагчид хадгалагдаж буй үнэт цаас, санхүүгийн хөрөнгө, эсхүл хэрэгслийг буцаан худалдан авах тухай гэрээ, түүнийг эзэмших, зээлэх, худалдахтай холбогдох баталгааны эрх шилжүүлэх.

2.Энэхүү конвенц нь вексель, өрийн бичиг, дагалдах бичиг, далайн тээвэрлэлтийн дагалдах бичиг, агуулахын тасалбар, эсхүл бараа бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэх, эсхүл үнэ төлөхийг шаардах эрхийг өмчлөгч, эсхүл үүрэг гүйцэтгүүлэгчид олгож буй хэрэгсэл, эсхүл шилжүүлэх боломжтой аливаа баримт бичигт үйлчлэхгүй.

*3 дугаар зүйл*  
**Талуудын бие даасан байдал**

Талууд энэ конвенцын зарим заалтаас татгалзах буюу тэдгээрийн үйлчлэлийг өөрчлөх, эсхүл энэхүү конвенцыг хэрэглэхээс татгалзаж болно.

**II БҮЛЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

*4 дүгээр зүйл*  
**Нэр томъёоны тодорхойлолт**

Энэхүү конвенцын зорилгоор:

- (a) “Харилцаа” гэж Талууд гэрээ байгуулах, эсхүл түүнийг биелүүлэхтэй холбогдуулан хийх буюу хийх ёстой гэрээний санал гаргах, түүнийг хүлээн авах зэрэг аливаа тайлбар, тунхаглал, шаардлага, хүсэлт, эсхүл мэдэгдлийг;
- (b) “Цахим харилцаа” гэж талууд хоорондын цахим мэдээ хэлбэртэй аливаа харилцааг;
- (c) “Цахим мэдээ” гэж цахим, соронзон, оптик болон ижил төрлийн тухайлбал цахим мэдээ солилцооны систем, цахим



шуудан, телеграмм, телекс, телекопи зэрэг хэрэгслээр үүсгэж, илгээж, эсхүл хадгалж буй мэдээг;

- (d) Цахим харилцааг “Илгээгч” гэж цахим харилцааг зөвхөн дамжуулагчийн хувиар гүйцэтгэсэн Талаас бусад цахим мэдээг илгээсэн, эсхүл хадгалах үйлдлээс өмнө цахим харилцааг үүсгэх ажиллагааг гүйцэтгэсэн Тал, эсхүл түүний төлөөлөгчийг;
- (e) Цахим харилцааг “Хүлээн авагч” гэж тухайн цахим харилцааг зөвхөн дамжуулагчийн хувиар гүйцэтгэсэн Талаас бусад тухайн цахим харилцааг хүлээн авахаар Илгээгчийн тодорхойлсон Тал;
- (f) “Мэдээллийн систем” гэж цахим мэдээ үүсгэх, илгээх, хүлээн авах, хадгалах болон боловсруулах системийг;
- (g) “Автоматжуулсан мэдээллийн систем” гэж үйлдэл эхлүүлэх, эсхүл үйлдэлд хариу үзүүлэх компьютерийн програм, цахим болон бусад автомат хэрэгсэл, эсхүл хүний оролцоо, хяналтгүйгээр үйлдлийг эхлүүлэх, цахим мэдээнд хариу үйлдэл гүйцэтгэх бүрдэл бүтээгдэхүүн, эсхүл түүний хэсгийг;
- (h) “Оршин байгаа газар” гэж тодорхой газраас тодорхой хугацаанд бараа нийлүүлэх, эсхүл үйлчилгээг үзүүлэх зэрэг эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэх зорилготойгоор түр хугацаанд байршин байгаа газраас бусад Талуудын оршин байгаа аливаа газрыг.

#### *5 дугаар зүйл* **Тайлбарлах**

1.Энэхүү конвенцыг тайлбарлахдаа түүний олон улсын шинж чанар, мөн түүнийг нэг мөр хэрэглэхийг дэмжих болон олон улсын худалдаанд үнэнч шударга байдлыг эрхэмлэх зайлшгүй шаардлагыг харгалзан үзвэл зохино.

2.Энэхүү конвенцоор зохицуулсан боловч конвенцод шууд шийдвэрлэхээр асуудлыг конвенцын үндэс болсон ерөнхий зарчмуудын дагуу шийдвэрлэх бөгөөд ийм зарчим байхгүй бол түүнийг олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээний дагуу хэрэглэгдэх эрх зүйн дагуу шийдвэрлэнэ.

#### *6 дугаар зүйл* **Талуудын байршил**

1.Энэхүү конвенцын зорилгын үүднээс аль нэг Талын мэдэгдсэн газар түүний оршин байгаа газар биш гэдгийг нөгөө Тал нотолсноос бусад



тохиолдолд тухайн мэдэгдсэн газрыг аливаа Талын оршин байгаа газар гэж үзнэ.

2.Хэрэв аль нэг Тал оршин байгаа газраа мэдэгдээгүй, эсхүл нэгээс дээш оршин байгаа газартай бол гэрээ байгуулахаас өмнө, эсхүл байгуулах үед тодорхой нөхцөл байдлын улмаас Талууд мэдэж байсан, эсхүл урьдчилан мэдэх боломжтой байсан бөгөөд холбогдох гэрээнд хамгийн ойрын хамаарал бүхий газрыг энэхүү конвенцын зорилгын үүднээс оршин байгаа газар гэж үзнэ.

3.Хэрэв хувь хүн оршин байгаа газар байхгүй бол түүний оршин суугаа газрыг оршин байгаа газар гэж үзнэ.

4.Дараах газар дангаараа оршин байгаа газар болохгүй. Учир нь:

(а) аль нэг Талын гэрээ байгуулахтай холбогдуулан ашиглаж буй мэдээллийн системийг дэмжих зорилготой техник, тоног төхөөрөмж байгаа газар; эсхүл

(b) нөгөө Талаас мэдээллийн системд хандах боломжтой газар.

5.Аль нэг Тал тодорхой нэг улсад харьяалагдах домэйн нэр, эсхүл цахим шуудангийн хаяг ашигласан нь түүнийг тухайн улсад оршин байгаа газартай гэж үзэх үндэслэл болохгүй.

#### *7 дугаар зүйл* **Мэдээлэх үүрэг**

Энэхүү конвенц нь Талуудын хувийн мэдээлэл, оршин байгаа газар, бусад мэдээллийг ил болгохыг шаардсан хууль тогтоожмийг хэрэглэх болон үүнтэй холбогдуулан буруу, таашаа, эсхүл бүрэн бус мэдээлэл өгсөн Талыг эрх зүйн үр дагавраас чөлөөлөх асуудлыг хөндөхгүй.

### **III БҮЛЭГ. ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНД ЦАХИМ ХАРИЛЦААГ АШИГЛАХ**

#### *8 дугаар зүйл* **Цахим харилцааг хуулиар хүлээн зөвшөөрөх**

1.Аливаа харилцаа, эсхүл гэрээг цахим хэлбэрээр үйлдсэн гэсэн ганцхан үндэслэлээр түүний хүчин төгөлдөр байдлыг, эсхүл нэхэмжлэлийн шаардлагыг үгүйсгэж болохгүй.

2.Энэхүү конвенцоор Талуудыг цахим харилцааг ашиглах, эсхүл хүлээн зөвшөөрөхийг шаардахгүй ч аль нэг Талын үйлдэл, эс үйлдэхүйгээс түүнийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэж болно.

*9 дүгээр зүйл*  
**Хэлбэрийн шаардлага**

1.Энэхүү конвенцоор аливаа харилцаа, эсхүл гэрээ тодорхой хэлбэртэй байх, эсхүл түүнийг нотлохыг шаардахгүй.

2.Хуульд заасны дагуу тухайн харилцаа, эсхүл гэрээг бичгээр үйлдэх, эсхүл бичгэн хэлбэртэй байх шаардлагыг хангаагүй нь эрх зүйн үр дагавар үүсгэхээр бол тухайн цахим харилцаанд агуулагдсан мэдээллийг дараа үзэх боломжтой байвал тухайн цахим харилцаа уг хуулийн шаардлагыг хангасан гэж үзнэ.

3.Хуульд заасны дагуу тухайн харилцаа, эсхүл гэрээнд гарын үсэг зурсан байхыг шаардсан, эсхүл гэрээнд гарын үсэг зураагүй нь хуулийн дагуу эрх зүйн үр дагавар үүсгэхээр бол дараах тохиолдолд цахим харилцааг уг хуулийн шаардлагыг хангасанд тооцно:

(a) Аль нэг Талыг тодорхойлох болон тухайн цахим харилцаанд агуулагдаж буй мэдээлэлтэй холбогдох түүний хүсэл зоригийг илэрхийлэх зохистой аргыг хэрэглэсэн бол; болон

(b) Хэрэглэсэн арга нь:

(i) бүх нөхцөлд, тухайлбал холбогдох гэрээг байгуулахад цахим харилцааны мэдээллийг үүсгэсэн, дамжуулсан нь зорилгод бүрэн нийцсэн; эсхүл

(ii) энэ хэсгийн (a) заалтад хэсэгт заасан чиг үүргийг бүрэн гүйцэтгэснийг өөрөө, эсхүл бусад баримтаар нотолсон бол.

4.Хуульд тухайн харилцаа, эсхүл гэрээний эх бичвэрийг хадгалахаар, эсхүл тухайн эх бичвэр байхгүй тохиолдолд эрх зүйн үр дагавар үүсэхээр заасан бол дараах тохиолдолд цахим харилцаа энэхүү шаардлагыг хангасанд тооцно:

(a) эцсийн хувилбараар анх удаа цахим хэлбэрт шилжсэнээс хойших цахим харилцааны баримт бичгийн мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хангаж байгаа баталгаа байгаа бол; болон

(b) агуулагдсан мэдээллийг хүртээмжтэй болгох шаардлагатай тохиолдолд тэрхүү мэдээлэлтэй танилцах этгээдэд үзүүлэх боломжтой бол.



5.Энэ зүйлийн 4 дэх хэсгийн (а) заалтын хүрээнд:

- (а) Солилцох, хадгалах, үзүүлэх шаардлагаар хийсэн ямар нэг нэмэлт, өөрчлөлтийг эс тооцон мэдээллийн бүрэн бүтэн, өөрчлөлтгүй байдлыг хангах шалгуур тогтооно; болон
- (б) Мэдээллийн найдвартай байдлын түвшинг үүсгэсэн зорилго болон бусад нөхцөл байдалд нийцэж байгаагаар үнэлнэ.

*10 дугаар зүйл*

### **Цахим харилцааг илгээх, хүлээн авах газар, хугацаа**

1.Цахим харилцааг илгээсэн цагийг тухайн цахим харилцаа Илгээгчийн, эсхүл илгээгчийн нэрийн өмнөөс илгээж буй этгээдийн хяналтад байгаа мэдээллийн системээс гарсан цагаар, эсхүл тухайн цахим харилцаа уг мэдээллийн системээс гараагүй тохиолдолд тухайн цахим харилцааг хүлээн авсан цагаар тооцно.

2.Цахим харилцааг хүлээн авсан цагийг Хүлээн авагч тал түүний тодорхойлсон цахим хаягаар тухайн цахим харилцаатай танилцах боломж бий болсон цагаар тооцно. Хүлээн авагчийн бусад цахим хаягт илгээсэн цахим харилцааг хүлээн авсан цагийг тухайн цахим харилцааг тус цахим хаяг руу илгээсэн гэдгийг Хүлээн авагч мэдсэн бөгөөд тус цахим хаягаар тухайн цахим харилцаатай танилцах боломж бий болсон цагаар тооцно. Цахим харилцаатай танилцах боломж бий болох гэдэгт тухайн цахим харилцаа Хүлээн авагчийн цахим хаягт ирсэн байхыг ойлгоно.

3.Илгээгчийн оршин байгаа газрыг цахим харилцаа илгээсэн газар, мөн Хүлээн авагчийн оршин байгаа газрыг цахим харилцаа хүлээн авсан газар гэж тооцно. Оршин байгаа газрыг 6 дугаар зүйлийн дагуу тодорхойлно.

4.Цахим хаягийг дэмжих мэдээллийн систем байрлаж буй байрлал нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан цахим харилцааг хүлээн авах байрлалаас өөр байхаас үл хамааран энэ зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэнэ.

*11 дүгээр зүйл*

### **Санал гаргах дуудлага**

Талуудад нээлттэй мэдээллийн системээр дамжуулан захиалга авах интерактив хэрэглээний программыг ашиглан гаргасан гэрээ байгуулах санал зэрэг мэдээллийн системийг хэрэглэгч Талуудад нээлттэй боловч, нэг эсхүл түүнээс дээш тодорхой Талуудад хандаагүй, нэг эсхүл түүнээс дээш цахим харилцаагаар дамжуулан гаргасан гэрээ байгуулах

саналыг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд гэрээний санал гаргагч Тал үүрэг хүлээхээр гэрээний саналд тодорхой заагаагүй бол санал гаргах дуудлага гэж үзнэ.

*12 дугаар зүйл*

**Гэрээ байгуулахад автоматжуулсан мэдээллийн системийг ашиглах**

Автоматжуулсан мэдээллийн систем болон хувь хүний харилцан үйлдлээр, эсхүл автоматжуулсан мэдээллийн системийн үйлдлээр байгуулагдсан гэрээний хүчин төгөлдөр байдал, шаардах эрхийг автоматжуулсан мэдээллийн системээр хийсэн аливаа үйлдэл, гэрээнд хувь хүний хяналт, оролцоо байгаагүй гэсэн ганц үндэслэлээр үгүйсгэж болохгүй.

*13 дугаар зүйл*

**Гэрээний нөхцөлийн хүртээмжтэй байдал**

Энэхүү конвенц нь цахим харилцааг солилцох замаар гэрээний нөхцөлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн тохиролцож буй аль нэг Тал гэрээний нөхцөлийг агуулж буй тэрхүү цахим харилцааг нөгөө Талд тодорхой арга хэлбэрээр гаргаж өгөх ёстой гэж заасан хууль тогтоомжийг хэрэглэх явдлыг хөндөхгүй бөгөөд уг шаардлагыг биелүүлээгүйгээс үүсэх эрх зүйн үр дагавраас аль нэг Талыг чөлөөлөхгүй.

*14 дүгээр зүйл*

**Цахим харилцаанд алдаа гарах**

1.Хувь хүн автоматжуулсан мэдээллийн системээр дамжуулан нөгөө Талд хүргүүлсэн цахим харилцаанд алдаатай мэдээлэл оруулсан бөгөөд тэрхүү автоматжуулсан мэдээллийн систем тухайн алдааг засах боломжийг түүнд олгоогүй бол тэр хувь хүн, эсхүл түүгээр төлөөлүүлсэн Тал алдаа гарсан цахим мэдээллийн хэсгийг хүчингүй болгох эрхтэй. Хэрэв:

- (a) Хувь хүн, эсхүл түүгээр төлөөлүүлсэн Тал алдаа гарсан тухай мэдсэний дараа нэн даруй цахим харилцаанд алдаа гарсан тухай нөгөө Талд мэдэгдэж, энэ тухай мэдээлэл өгсөн бол;
- (b) Хувь хүн, эсхүл түүгээр төлөөлүүлсэн Тал нөгөө Талаас хүлээн авсан бараа, эсхүл үйлчилгээг ашиглаагүй, эсхүл тэдгээрээс эд юмсын болон эрхийн үр шим хүртээгүй бол.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас өөр алдаанаас үүдэлтэй аливаа хууль тогтоомжийн хэрэглэх явдлыг энэ зүйл хөндөхгүй.





#### **IV БҮЛЭГ. ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД**

##### *15 дугаар зүйл* **Хадгалагч**

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү конвенцын эх хадгалагч болно.

##### *16 дугаар зүйл* **Гарын үсэг, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах**

1.Энэхүү конвенц нь 2006 оны 1 дүгээр сарын 16-ны өдрөөс 2008 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл Нью-Йорк дахь Нэгдсэн Үндэстний Байгууллагын төв байранд бүх улс гарын үсэг зурахад нээлттэй байна.

2.Энэхүү конвенцод гарын үсэг зурсан бүх улс түүнийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл батална.

3.Энэхүү конвенцод гарын үсэг зураагүй бүх улс гарын үсэг зурахад нээлттэй болсон өдрөөс хойш түүнд нэгдэн орж болно.

4.Энэхүү конвенцыг соёрхон баталсан батламж жуух бичиг, хүлээн зөвшөөрсөн, баталсан, нэгдэн орсон тухай баримт бичгийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

##### *17 дугаар зүйл* **Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын оролцоо**

1.Энэхүү конвенцоор зохицуулсан зарим асуудлыг шийдвэрлэхээр тусгаар тогтносон улсуудын үүсгэн байгуулсан Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага мөн адил энэхүү конвенцод гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл түүнд нэгдэн орж болно. Энэ тохиолдолд Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага нь энэхүү конвенцоор зохицуулсан асуудлыг шийдвэрлэх хэмжээнд оролцогч улсын хүлээсэн эрх, үүргийг эдэлнэ. Энэхүү конвенцын гишүүн улсын тоо ач холбогдол бүхий бол Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагыг конвенцын оролцогч улс болох тус байгууллагын гишүүн улс дээр нэмж конвенцын оролцогч улсаар тоолохгүй.

2.Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага энэхүү конвенцод гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл нэгдэн орох үедээ тус байгууллагын гишүүн улсаас түүнд шилжүүлсэн бүрэн эрхийн хүрээнд энэхүү конвенцоор зохицуулагдах асуудлыг тодорхойлсон мэдэгдлийг эх хадгалагчид гаргана. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага энэ хэсэгт заасны дагуу

гаргасан мэдэгдэлд тодорхойлсон бүрэн эрхийн хуваарилалтад орсон аливаа өөрчлөлт, түүний дотор бүрэн эрхийг шинээр шилжүүлсэн, авсан тухай эх хадгалагчид нэн даруй мэдэгдэнэ.

3.Энэхүү конвенцод заасан “Хэлэлцэн тохиролцогч улс”, эсхүл “Хэлэлцэн тохиролцогч улсууд” гэсэн нэр томьёо нь Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагад адил хамаарна.

4.Энэхүү конвенц нь 21 дүгээр зүйлд заасан мэдэгдлийн дагуу аливаа бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын гишүүн улсад оршин байгаа байршилтай Талуудад үйлчлэх тэрхүү байгууллагын журамтай зөрчилдвөл давуу байдал эдлэхгүй.

#### *18 дугаар зүйл*

### **Дотоодын нутаг дэвсгэрийн нэгжид үйлчлэх**

1.Оролцогч улс нутаг дэвсгэрийн хоёр ба түүнээс дээш нэгжтэй бөгөөд тэдгээр нэгжид энэхүү конвенцод тусгасан зүйлийг эрх зүйн өөр өөр системээр зохицуулдаг бол тэр улс энэхүү конвенцод гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, эсхүл нэгдэн орох үедээ энэхүү конвенц нутаг дэвсгэрийнх нь бүх нэгжид, эсхүл нэг буюу хэд хэдэн нутаг дэвсгэрийн нэгжид хүчинтэй байхыг мэдэгдэж болох бөгөөд мөн аль ч үед дахин мэдэгдэл гаргах замаар эхний мэдэгдэлд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

2.Эдгээр мэдэгдлийг конвенц хадгалагчид мэдэгдэх бөгөөд түүндээ энэхүү конвенц үйлчлэх нутаг дэвсгэрийн нэгжийг тодорхой зааж өгнө.

3.Энэ зүйлийн дагуу хийсэн мэдэгдлийн улмаас энэхүү конвенц нь Оролцогч аль нэг улсын нутаг дэвсгэрийнх нь бүх нэгжид бус, нэг буюу хэд хэдэн нэгжид хүчинтэй байгаа бөгөөд уг улсад аль нэг Талын оршин байгаа газар байрлаж байгаа бол энэхүү конвенц үйлчлэх тухайн улсын нутаг дэвсгэрийн нэгжид тэр оршин байгаа газар байрлах тохиолдолд л энэхүү конвенцын зорилгын үүднээс түүнийг Оролцогч улсад оршин байна гэж үзнэ.

4.Оролцогч улс энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу мэдэгдэл гаргаагүй бол энэхүү конвенц нутаг дэвсгэрийнх нь бүх нэгжид үйлчилнэ.

#### *19 дүгээр зүйл*

### **Хамрах хүрээний талаарх мэдэгдэл**

1.Оролцогч аливаа улс энэхүү конвенцыг хэрэглэх талаар 21 дүгээр зүйлийн дагуу мэдэгдэл гаргаж болно:



- (a) 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан улс нь энэхүү конвенцын Оролцогч улс мөн бол, эсхүл
- (b) Талууд энэхүү конвенцыг хэрэглэхээр харилцан тохиролцсон бол.

2.Оролцогч аливаа улс 21 дүгээр зүйлийн дагуу гаргасан мэдэгдэлд тодорхойлсон зүйлийг энэхүү конвенцын хэрэглэх хүрээнээс хасч болно.

### *20 дугаар зүйл*

#### **Бусад олон улсын гэрээний дагуу харилцаа солилцох**

1.Дараах олон улсын гэрээний гишүүн, эсхүл гишүүн болох, энэхүү конвенцын оролцогч улс нь эдгээр олон улсын гэрээгээр зохицуулагдах гэрээг байгуулах, эсхүл хэрэгжүүлэхтэй холбогдуулан цахим харилцааг ашиглахдаа энэхүү конвенцын заалтыг хэрэглэж болно.

Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай конвенц (Нью-Йорк хот, 1958 оны 6 дугаар сарын 10-ны өдөр);

Олон улсын бараа худалдахад хөөн хэлэлцэх хугацааны тухай конвенц (Нью-Йорк хот, 1974 оны 6 дугаар сарын 14-ний өдөр) ба түүний протокол (Вена хот, 1980 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр);

Бараа худалдах-худалдан авах олон улсын гэрээний тухай Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенц (Вена хот, 1980 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр);

Олон улсын худалдаанд тээвэрлэлтийн терминалын операторын хариуцлагын тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц (Вена хот, 1991 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр);

Бие даасан батлан даагчид болон Банкны баталгааны тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц (Нью-Йорк хот, 1995 оны 12 дугаар сарын 11-ний өдөр);

Олон улсын худалдаанд эрх шилжүүлэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц (Нью-Йорк, 2001 оны 12 дугаар сарын 12-ны өдөр);

2.Энэ хэсгийг дагаж мөрдөхгүй тухай оролцогч улс энэхүү конвенцын 21 дүгээр зүйлийн дагуу мэдэгдэл гаргаснаас бусад тохиолдолд энэ зүйлийн 1 дэх хэсэгт тусгайлан зааснаас бусад олон улсын гэрээний гишүүн, эсхүл түүний гишүүн болох Оролцогч улс нь уг олон улсын гэрээгээр зохицуулагдах гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан цахим харилцааг ашиглахдаа энэхүү конвенцыг мөн адил хэрэглэнэ.



3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу мэдэгдэл гаргасан, тодорхой нэг олон улсын гэрээний гишүүн, эсхүл гишүүн болох Оролцогч улс нь уг олон улсын гэрээгээр зохицуулагдах гэрээг байгуулах, эсхүл хэрэгжүүлэхтэй холбогдуулан цахим харилцаа ашиглахдаа энэхүү конвенцын заалтуудыг хэрэглэх тухай мөн мэдэгдэл гаргаж болно.

4.Энэ зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх тухай 21 дүгээр зүйлд нийцүүлэн мэдэгдэл гаргаснаас үл хамааран Оролцогч улс, эсхүл Оролцогч улс болох улс нь аливаа олон улсын гэрээнд, түүний дотор энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан конвенцоор зохицуулах гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан цахим харилцааг ашиглахдаа энэхүү конвенцын заалтуудыг хэрэглэхгүй байх талаар тунхаглал гаргаж болно.

#### *21 дүгээр зүйл*

### **Мэдэгдэл гаргах журам болон үйлчлэл**

1.17 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 2, 3 болон 4 дэх хэсэгт тус тус заасан мэдэгдлийг аль ч үед гаргаж болно. Гарын үсэг зурах үед гаргасан мэдэгдлийг соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, эсхүл батлах үед нотолно.

2.Мэдэгдэл болон түүний нотолгоог бичгээр үйлдэж, эх хадгалагчид албан ёсоор мэдээлнэ.

3.Мэдэгдэл нь тухайн улсын хувьд энэхүү конвенц хүчин төгөлдөр болохтой нэгэн зэрэг хүчин төгөлдөр болно. Харин ийнхүү хүчин төгөлдөр болсны дараа мэдэгдлийг эх хадгалагчид албан ёсоор нотлон мэдэгдсэн бол уг мэдэгдэл нь эх хадгалагч нотолгоог хүлээн авснаас хойш зургаан сар өнгөрсний дараагийн сарын эхний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлнэ.

4.Энэхүү конвенцын дагуу мэдэгдэл хийсэн аливаа улс эх хадгалагчид албан ёсоор бичгээр сонордуулж аль ч үед уг мэдэгдэлд өөрчлөлт оруулж, эсхүл мэдэгдлээсээ татгалзаж болно. Ийнхүү мэдэгдэлд өөрчлөлт оруулах, эсхүл мэдэгдлээсээ татгалзах нь албан ёсны сонордуулгыг хадгалагч хүлээн авснаас хойш зургаан сар өнгөрсний дараагийн сарын эхний өдрөөс хүчин төгөлдөр болно.

#### *22 дугаар зүйл*

### **Тайлбар хийх**

Энэхүү конвенцын дагуу тайлбар хийхгүй.

#### *23 дугаар зүйл*

### **Хүчин төгөлдөр болох**

1.Энэхүү конвенц нь соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан буюу нэгдэн орсон тухай 3 дахь Батламж жуух бичгийг эх



хадгалагчид хадгалуулснаас хойш зургаан сар өнгөрсний дараагийн сарын эхний өдрөөс хүчин төгөлдөр болно.

2.Соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан буюу нэгдэн орсон тухай 3 дахь Батламж жуух бичгийг эх хадгалагчид хадгалуулснаас хойш соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах буюу түүнд нэгдэн орох улсын хувьд түүнийг соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан буюу нэгдэн орсон тухай Батламж жуух бичгээ хадгалагчид хадгалуулснаас хойш зургаан сар өнгөрсний дараагийн сарын эхний өдрөөс уг конвенц хүчин төгөлдөр болно.

#### *24 дүгээр зүйл* **Үйлчлэх хугацаа**

Энэхүү конвенц, эсхүл мэдэгдлийг Оролцогч аливаа улсад энэхүү конвенц, эсхүл мэдэгдэл хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хийгдсэн цахим харилцаанд зөвхөн хэрэглэнэ.

#### *25 дугаар зүйл* **Цуцлах**

1.Оролцогч аливаа улс энэхүү конвенцыг эх хадгалагчид бичгээр мэдэгдэн цуцалж болно.

2.Цуцлах тухай мэдэгдлийг эх хадгалагч хүлээн авснаас хойш 12 сар өнгөрсний дараагийн сарын эхний өдрөөс цуцлалт хүчин төгөлдөр болно. Мэдэгдэлд үүнээс урт хугацааны дараа цуцлалт хүчин төгөлдөр болохоор заасан бол энэ мэдэгдлийг эх хадгалагч хүлээн авснаас хойш уг урт хугацаа өнгөрсний дараа цуцлалт хүчин төгөлдөр болно.

Нью-Йорк хотноо 2005 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Араб, Хятад, Англи, Франц, Орос, Испани хэлээр тус бүр нэг хувьд үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй.

**ХЭМЭЭСНИЙГ НОТЛОН** тус тусын Засгийн газраас зохих ёсоор олгосон бүрэн эрх бүхий төлөөлөгчид энэхүү конвенцод гарын үсэг зурав.

#### **Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medelel@parliament.mn](mailto:turiin_medelel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 2.25

**Индекс: 200003**